# Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

## Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газар

## 2024 оны жилийн эцэс

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Тус газраас 2024 онд мэдвэл зохих хууль тогтоомжийн, албан хаагчдыг хөгжүүлэх сургалт гэсэн 2 чиглэл,24 сэдвээр сургалтын төлөвлөгөө баталж, сар бүр 2 сургалт зохион байгуулан 100 хувь хэрэгжсэн, БТСУХорооноос зохион байгуулсан чадавхжуулах сургалтанд биеийн тамирын арга зүйч нарыг хамруулж мэргэшүүлж, ТАЗ-өөс зохион байгуулдаг цахим сургалтанд албан хаагчдын хамруулсан. 2024 онд “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-г 27 заалтаар гаргаж ажил арга хэмжээг зохион байгуулан, хөтөлбөрийн биелэлт 96,2 хувьтай хэрэгжсэн.Нийт албан хаагчдад ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал, ур чадварын, зэргийн нэмэгдэл, хоол унааны зардал, орон нутгийн нэмэгдэл,өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 1 ажилтан, аав, ээж, төрсөн ах нь нас барсан 3 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.“Цагаан сар”, Ахмадын баярыг тохиолдуулан байгууллагын 14 ахмад, эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан эмэгтэй албан хаагч, Хүүхдийн баярын өдөр ажилтнуудын хүүхдүүдэд тусгай хөтөлбөрийн дагуу хүндэтгэл үзүүлж бэлэг дурсгалын зүйл гардуулах арга хэмжээг тус тус зохион байгуулсан. Биеийн тамир, спортын байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан 2 албан хаагчийг төрийн дээд шагнал олгуулахаар материалыг хүргүүлж, шагнаж урамшуулсан. Мөн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж өрөө тасалгаа, амралтын өрөөг тохижуулж, үйлчилгээний ажилтнуудыг 2 ээлжийн ажлын хувцасаар хангасан. Ажилтнуудын сайн дурын үндсэн дээр байгуулагдсан "Хамтын сан"-гаас давхардсан тоогоор 48 ажилтанд төгрөгийн 2,350,000 төг-ийн мөнгөн тусламж үзүүлсэн.гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс авахад тусламж үзүүлсэн. Улаанбаатар хотод нарийн мэргэжлийн эмнэлэгт үзүүлж онош тодруулах, ар гэрийн гачигдал, гэр бүлийн гишүүдээ асрахаар гаргасан 16 албан хаагчид цалинтай чөлөө олгож, ажлын бус цагаар болон амралтын өдрөөр ажилласан 28 албан хаагчдыг нөхөж амраасан. | 100% |
| 2 | 2 | Нийтийн мэдээллийн ил тод | 8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн | Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газраас 2024 онд Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн цахим санд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 16, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний 15, нийт 31 заалтын | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01 | хэрэгжилтийн тайлан; | биелэлтийг хугацаанд нь цахимаар тайлагнаж, Монгол Улсын сайд, олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Дорноговь аймгийн Засаг даргатай байгуулсан Биеийн тамир, спортын салбарт 2024 онд хамтран ажиллах гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр, байгууллагын стратеги төлөвлөгөөний 2023-2024 оны биелэлтийг 34 заалтаар гаргаж Биеийн тамир, спортын улсын хороонд тус тус хугацаанд нь тайлагнасан. | |
| | 3 | | 8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | Биеийн тамир, спортын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Биеийн тамир спортын тухай хууль, Төрийн албаны тухай хууль бусад хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус газраас аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/675 дугаартай захирамжаар баталсан "Аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх тайлангийн хуваарь", Дорноговь аймгийн Засаг дарга Монгол Улсын Сайд нартай байгуулсан гэрээг тайлагнах хуваарийн дагуу, Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн цахим санд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 16, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний 15, нийт 31 заалтын биелэлтийг хугацаанд нь цахимаар тайлагнаж ажилласан. Мөн Монгол Улсын сайд, олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Дорноговь аймгийн Засаг даргатай байгуулсан Биеийн тамир, спортын салбарт 2024 онд хамтран ажиллах гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр, байгууллагын стратеги төлөвлөгөөний 2023-2024 оны биелэлтийг 34 заалтаар БТСУХороонд, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээг улирал бүр, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг тус тус гаргаж хүргүүлсэн. | 100% |
| | 4 | | 8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | Тус газрын албан хаагч, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг Биеийн тамир, спортын газрын дарга батлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Бүтэц үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар зэргийг цахим хуудсанд байршуулсан. Харилцах утасны дугаар: 70520012, И-мэйл хаяг: dornogovi@sport.gov.mn, Дорноговь Биеийн Тамир Спортын Газар цахим хуудас, Вэб сайт: dornogovi.sport.gov.mn хаягаар байгууллагаас зохион байгуулж буй тэмцээн уралдаан болон бусад мэдээллийг байршуулан ажиллаж байна. | 100% |
| | 5 | | 8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | Биеийн тамир, спортын газар нь 2024 онд 124 өргөдөл, гомдол хүлээн авснаас ажилд орох 11, өөрийн санаачилгаар чөлөөлөгдөх 8, хүүхэд асрах чөлөө авах 1, өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор чөлөөлөгдөх 1, тэтгэмж төсөвт суулгуулах 1, захиргааны чөлөө хүссэн 54, бусад асуудлаар 48 өргөдөл бүртгэгдсэнээс 75 буюу 60,5 хувь нь ажилд орох томилуулах, түр чөлөөлөгдөх, чөлөөлөгдөх, чөлөө хүссэн асуудлаар, 1 буюу 0,8 хувь тэтгэмж олгуулах, 48 буюу 38,7 хувь нь бусад асуудлаар хандсан байна.Нийт өргөдөл гомдлыг цаасаар ирүүлсэн бөгөөд иргэдээс болон байгууллагын ахмад ажилтнаас ирүүлсэн өргөдөл 36 буюу 29,0 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хувь, албан хаагч, ажилтнуудаас ирүүлсэн өргөдөл 88 буюу 71,0 хувийг эзэлж 100 хувь хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан. Иргэдээс ирүүлсэн гомдол бүртгэгдээгүй, өөр байгууллагад шилжүүлсэн өргөдөл байхгүй, ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан ажилтнуудын шалтгаан нөхцөлийг судлахад ар гэрийн шалтгааны улмаас, цалин хангамж хангалтгүй тул өөр ажилд орох, өвчний учир эмчилгээ хийлгэх, өвчтэй хүн асрах, гэр бүлийн хүн шилжиж байгаа, БНСУ-д виз мэдүүлсэн шалтгааны улмаас ажлаас чөлөөлөгдөж байгаа болно. Мэдээг улирал тутам аймгийн ЗДТГ-т хүргүүлж ажиласан. | |
| | 6 | | 8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | Биеийн тамир, спортын газарт Үндэсний спортын төрөл болох сур харваагаар 16-54 насны 142, урианхай сур харваагаар 45-54 насны 6, буриад сур харваагаар 35-44 насны 10, уламжлалт харваагаар 45-54 насны 11, шагайн харваагаар 16-54 насны ангилалд 582 иргэн, халз тулаан, хүчний спорт болох жүдо бөхийн төрлөөр 6-16 насны 60, чөлөөт бөхөөр 6-16 нас 40, жюү-жицү бөхөөр 16-19 насны 78, бокс 16-18 насны 55, олон улсын таеквондогоор 16-19 насны 31 тамирчин, спорт тоглоомын төрлөөр сагсан бөмбөгөөр 16-20 насны 765 , волейбол 16-20 насны 572, гандболоор 16-18 насны 72, бадминтоноор 16-18 насны 29 тамирчин, оюуны спортын төрөл шатрын спортоор 213 тамирчин, хэмжигдэхүүнтэй спортын төрөл Дартсын төрөлд 16-19 насны 32, хөнгөн атлетикаар 16-21 насны 70, бүжгийн төрлөөр 16 насны 18, 20 насны-10, 25-34 насны-10 иргэн, дугуйн спортоор 16-20 насны 86 тамирчин тус тус хичээллэж байна. Үйл ажиллагааны статистик тоо, тоон мэдээллийг 7 хоног, сар, улирал, жилээр гарган тайлан мэдээндээ нэгтгэн хүргүүлдэг. | 100% |
| | 8 | | 8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/73 дугаартай захирамжаар тус газрын бүтэц, орон тоог 70 албан хаагч, ажилтантай байхаар баталснаас 14 орон тоо сул (биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийн ахлах мэргэжилтэн, усан спортын төвийн зохион байгуулагч, эмч, бичиг хэрэг, архивын ажилтан, жижүүр-4, Сайншанд сумын 5 дугаар баг /Зүүнбаян/, Замын-Үүд, Өргөн сумдын биеийн тамирын арга зүйч, Хөвсгөл, Хатанбулаг сумдын дасгалжуулагч) байна. Сул орон тооны зарыг байгууллагын dornogovi.sport.gov.mn вэб хуудсанд байршуулж, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлж, FM радио, телевизүүдээр нэвтрүүлэн, ажил идэвхитэй хайж байгаа иргэдэд танилцуулан ажилласан. | 100% |
| | 9 | | 8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | 2024 онд тус байгууллагын төрийн захиргааны албан тушаал биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийн ахлах мэргэжилтний сул орон тоонд Төрийн албаны сонгон шалгаруулах журмын дагуу тусгай шалгалт өгч тэнцсэн 1 албан хаагч, төрийн үйлчилгээний албан тушаалын сул орон тоонд шалгуур, шаардлага хангасан нягтлан бодогч, волейболын дасгалжуулагч, бичиг хэрэг, архивын ажилтан, жижүүр-2, Иххэт сумын дасгалжуулагч, Замын-Үүд, Өргөн, Хөвсгөл | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | сумдын үйлчлэгч, Зүүнбаян багийн жижүүрийн албан тушаалд 3, гэрээт боксын дасгалжуулагчаар албан тушаалын тодорхойлолтод заагдсан шалгуур, шаардлага хангасан 14 иргэнийг судалж томилсон. | |
| | 10 | | 8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | Монгол Улсын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу газрын даргын 2024 оны А/04 дүгээр тушаалаар "Ёс зүйн дэд зөвлөл"-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталж, 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны олон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-гээр сургалт зохион байгуулж, байгууллагын мэдээллийн самбарт байрлуулж, ажилтан бүрт хэвлэн өгч судлуулж, байгууллагын "Дотоод журам"-д ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тусгаж, ажилтнуудын ажил дүгнэх үзүүлэлтэнд харгалзан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2024 онд тус газраас ёс зүйн зөрчил гаргаж 3 албан хаагч хөдөлмөрийн сахилгын арга хэмжээ авагдсан болно. Сахилгын арга хэмжээ авагдсан албан хаагчдын тоо урьд оны мөн үеэс 1-ээр буюу 50 хувиар өссөн үзүүлэлтэй, энэ нь дотоодын хяналт шалгалт сайжирсантай холбоотой гэж дүгнэж байна. Мөн аймгийн Засаг даргын 2021 оны "Төрийн абланы ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх тухай" албан даалгаврыг хэрэгжүүлэх, аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн уг албан даалгавын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар ирүүлсэн албан бичгийг албан хаагчдад танилцуулж, 2 удаа баталгаа гаргуулан авч ажилласан. Албан даалгаврын хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тайлагнасан. | 100% |
| | 11 | | 8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/73 дугаартай захирамжаар тус газрын бүтэц, орон тоог 70 албан хаагч, ажилтантай байхаар баталснаас 14 орон тоо сул (биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийн ахлах мэргэжилтэн, усан спортын төвийн зохион байгуулагч, эмч, бичиг хэрэг, архивын ажилтан, жижүүр-4, Сайншанд сумын 5 дугаар баг /Зүүнбаян/, Замын-Үүд, Өргөн сумдын биеийн тамирын арга зүйч, Хөвсгөл, Хатанбулаг сумдын дасгалжуулагч), орон тооны нөхөн хангалт 80.0 хувьтай ажиллаж байна. Сул орон тооны зарыг байгууллагын dornogovi.sport.gov.mn вэб хуудсанд байршуулж, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлж FM радио, телевизүүдээр нэвтрүүлэн, ажил идэвхитэй хайж байгаа иргэдэд танилцуулан ажиллаж 2024 онд ажлын байрны шалгуур, шаардлага хангасан 14 албан хаагчдын ажлын байранд томилж, дадлагажуулан ажилласан. Сургалтын төлөвлөгөө 2024 онд мэдвэл зохих хууль тогтоомжийн, албан хаагчдыг хөгжүүлэх сургалт гэсэн 2 чиглэл, 24 сэдвээр баталж, сар бүр 2 сургалт зохион байгуулан ажиллаж байна. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, үйл ажиллагааг үнэн зөв, шударга, ажлыг бодитой дүгнэхэд анхаарч Биеийн тамир, спортын газрын даргын 2024 оны А/40 дугаар | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | тушаалаар шинэчлэн баталсан "Байгууллагын албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, үр дүнгийн урамшуулал олгох журам"-ын дагуу албан хаагчдын ажлыг зөвлөлийн хурлаар нэгбүрчилэн хэлэлцэж 2024 онд 20-50 хувийн мөнгөн урамшуулал албан хаагчдад олгосон. | |
| | 12 | | 8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Биеийн тамир, спортын газрын сул орон тооны талаарх мэдээллийг тухай бүр шинэчлэн байгууллагын цахим хуудас, фейсбүүк хуудаст байршуулан аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлж FM радио, телевизүүдээр нэвтрүүлэн иргэдэд мэдээллийг ил тод, түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/73 дугаартай захирамжаар тус газрын бүтэц, орон тоог 70 орон тоотойгоор баталсан. Одоо ажиллаж байгаа 56 албан хаагч ажилтан, 14 орон тоо дутуу ажиллаж, орон тооны нөхөн хангалт 80.0 хувьтай байна. Сул ажлын байр биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийн ахлах мэргэжилтэн, нягтлан бодогч, волейболын дасгалжуулагч, боксын дасгалжуулагч, бичиг хэрэг, архивын ажилтан, жижүүр 2 , Иххэт сумын дасгалжуулагч, Замын-Үүд, Өргөн, Хөвсгөл сумын үйлчлэгч, Зүүнбаян багийн жижүүр ажлын байранд 3, нийт 14 албан хаагчийг албан тушаалын тодорхойлолтод заасан шалгуур, шаардлагыг баримтлан томилж ажилласан. Шинээр ажилд ажиллуулах, ажлаас чөлөөлөгдөхөд газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэж, гарсан шийдвэрийг албан хаагч ажилтнуудад танилцуулж хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг ханган ажиллаж байна. | 100% |
| | 13 | | 8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Биеийн тамир, спортын газрын даргын 2024 оны А/40 дүгээр тушаалаар "Байгууллагын албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, үр дүнгийн урамшуулал олгох журам"-ыг шинэчлэн баталж, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, үйл ажиллагааг үнэн зөв, шударга, ажлыг бодитой дүгнэхэд анхаар ажилтнуудын ажлыг дүгнэж даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар нэгбүрчилэн хэлэлцэж 2024 онд 20-50 хувийн мөнгөн урамшуулал төвийн албан хаагчдад олгосон. | 100% |
| | 14 | | 8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | 2024 оны нийт батлагдсан төсөв 1115349,7 мянган төгрөг үүнээс 11 дүгаар сарын байдлаар 1035604,7 мянган төгрөг батлагдаж 764121,3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гарган ажиллаж байна. | 100% |
| | 15 | | 8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2023 оны санхүүгийн тайлан, гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар ДГА-2024/130/НА-СТА-ТШЗ дугаартай менежментийн захидалд: 1.Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглагдахгүй хөрөнгийг акталж данснаас хасах байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа хөрөнгийг дахин шинээр үнэ тогтоох асуудлыг шийдвэрлэх: | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Газрын даргын 2024.06.07-ны өдрийн А/38 дугаар тушаалаар Эд хөрөнгийн тооллого явуулах комисс томилогдон ажиллаж, эд хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан, ашиглахгүй болсон үндсэн хөрөнгө болох бага үнэтэй хөрөнгийн жагсаалтыг гарган газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлэсэн. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор заасан хугацаанд нь албан бичгээр хүргүүлж https://fas.audit.mn/ аудитын системд байршуулсан. Мөн Төрийн аудитын газрын 2024.03.07-ны өдөр ирүүлсэн албан шаардлагын биелэлтийг 100 хувь хангаж хугацаанд нь тайланг хүргүүлсэн. 2. Шилэн дансны системийн мэдээллийг хугацаа хоцроохгүй байршуулах: Шилэн дансны системд байршуулах сар улирлын тайлан, мэдээллийг хуулийн хугацаанд тогтмол байршуулан мэдээлсэн ба 2024 онд нийт 171 мэдээлэл байршуулахаас 11 сард 151 мэдээллийг хуулийн хугацаанд нь, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна. 18 мэдээллийг байршуулахаар хуулийн хугацаандаа хүлээгдэж байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор заасан хугацаанд нь хүргүүлсэн байна. Биеийн тамир спортын улсын хорооны 2024 оны 04 сарын 17-ны өдрийн 6/459 дугаартай албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Шилэн дансны 3-р улирлын тайланг 10 сарын 5-ны хүргүүлсэн.. | |
| | 16 | | 8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; | Хууль тогтоомжийн хүрээнд Газрын даргын 2024 оны 02 сарын 20-ны өдрийн А/12 дугаар бүхий тушаалаар Байгууллагын эд хөрөнгөөр үйлчилгээ үзүүлэх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоосон, Аймгийн ИТХ-н Тэргүүлэгчдийн 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 72 дугаар тогтоол "орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ын хавсралтаар батлагдсан Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод тогтоогдсонтой холбогдуулан дээрхи үнийг баримтлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2024 он гарсаар Сурталчилгааны самбарын түрээс, онооны самбарын түрээс, Спорт цогцолборын заалны түрээс Спортын ордны заалны цагийн болон тэмцээний түрээс, ашиглахгүй байгаа зарим өрөөг фитнес, цайны газрын үйлчилгээ явуулах зэрэг байдлаар тус тус түрээслүүлэн давхардсан тоогоор 80 аж ахуй нэгж байгууллага, хувь хүнтэй түрээсийн гэрээ байгуулан 69869,1 сая төгрөгийн өөрийн орлогыг төвлөрүүлэн ажилласан байна. | 100% |
| | 17 | | 8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; | 2024 онд нийт 1,115,349.7 мянган төгрөгийн төсөв батлагдсан. 11 сарын байдлаар 1,035,604,7 мянган төгрөг батлагдаж 764121,3 мянган төгрөгийн төсвийн зарцуулалтын гүйцэтгэлтэй, 271483,4 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт үүссэн байна. Аймгийн Засаг даргын 2023 оны А/73 дугаартай тушаалаар 70 орон тоотой ажиллахаар батлагдсан. Үүнээс: - аймгийн төвд - орон тоотой, 9 сумданд -27 орон тоотой батлагдсан ба үүнээс аймгийн төвд 33 ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна. 2024 оны 11 дугаар сарын байдлаар 10 орон дутуу учир цалингийн санг 271483,4 мянган төгрөгөөр хэмнэн ажилласан.Төрийн хэмнэлтийн | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж 2024 онд төсвийг 24 хувиар хэмнэн ажилласан байна. | |
| | 18 | | 8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | 2024 онд Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааг хэвийн явуулах, ажиллах албан хаагчдыг ажиллах орчин нөхцөлөөр хангах ажлын хүрээнд шаардлагатай техник хэрэгсэл, урсгал засварын материал, спортын хэрэгсэл худалдан авахад 5-н байгууллагаас 31756,8 мян.төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| | 19 | | 8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | Улсын төсвийн санхүүжилтын орлого 760175.1 мянган төгрөг, 2024.06.19 нд аймгийн ЗДТГазраас орон нутгийн нэмэгдлийн 12,728.7 мянган төгрөгийн данс андуурсан гүйлгээний орлогыг тус тус үндсэн дансаар хүлээн авсан. Аймгийн ЗДТГазраас орон нутгийн нэмэгдэл болон сумдын ажилчдын цалин санхүүжилтэнд 642151.8 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд тус тус хүлээн авсан байна. Аймгийн ЗДТГазраас Тогтмол зардлын санхүүжилтэнд 316379,0 мянган төгрөгийн санхүүжилтийн орлогыг Тогтмол зардлын дансанд хүлээн авсан. Тогтмол зардлын данснаас Цэвэр бохир ус, Халаалтын зардлыг Чандмань-Илч ХХК-нд 444486,3 мянган төгрөгийн гүйлгээг хийсэн байна. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажилагааг хэвийн явуулахад шаардлагатай спортын техник хэрэгсэл болон урсгал засварын материал, техник хэрэгсэл авахад 5 удаагийн нийт 30385,6 мян.төгрөгийн зарцуулалтыг хийсэн байна<br><br>Хавсралт : 2 файл | 100% |
| | 20 | | 8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | Биеийн тамир, спортын улсын хорооны 2024.04.17-ны өдрийн 6/459 дугаартай албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд төсвийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаан шилэн дансанд оруулах санхүүгийн сар, улирлын мэдээ, тайланг хуулийн хугацаанд оруулан тогтмол мэдээлж байна. 2024 онд нийт 171 мэдээлэл байршуулахаас эхний 11 сарын байдлаар 153 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж 12 сард 18 мэдээлэл байршуулахаар хуулийн хугацаандаа хүлээгдэж байна. | 100% |
| | 26 | | 8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | 2024 оны 11 сарын байдлаар Шилэн дансны нэгдсэн сайтад төсөв, санхүүгийн нийт 153 мэдээлэл байршуулахаас 153 төрлийн мэдээллийг шилэн дансны хуулийн дагуу "6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтын дагуу сар, улирал, жилээр нь бүрэн гүйцэд үнэн зөв мэдээллийг оруулсан байна. Санхүү үйл ажиллагааны мэдээг сар бүрийн 1-ний дотор гарган холбогдох газарт хүргүүлэн удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангаан ажилласан. 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | дүгнэлт, 04 дүгээр улирлын санхүүгийн тайлан, 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлан, 2025 оны төсвийн төсөл зэрэг мэдээллийг хуулийн хугацаанд нь байршуулсан, Мөн байгууллагын мэдээллийн самбарт мэдээ тайланг тухай бүрт нь байршуулан ажиллаж байна. | |
| 3 | 41 | Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-10-19 Дугаар 2021 №8 БСШУСБХ | 1.1/. Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай: 1/ Биеийн тамир спортын тухай хууль, МУЗГ-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг МУЗГ, бүх шатны ИТХ, аймаг, нийслэлийн Засаг дарга, биеийн тамир, спортын Улсын хороо хангаж ажиллах; | Спортын холбоодтой хамтран Дорноговь опен Жюү жицүгийн олон улсын нээлттэй тэмцээн, Сагсан бөмбөгийн Үндэсний супер лигийн бүсийн финалын тоглолт, Говийн бүсийн шагайн харваан тэмцээн, Зүүн бүсийн шатарчдын аварга шалгаруулах тэмцээн, Чөлөөт бөх, жүдо, шатар, даам, дугуй, бокс, шагайн харваа, нийтийн бүжиг, үндэсний бөх, волейболын өсвөрийн болон насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүд, Сагсан бөмбөгийн Говь гаяс лиг, Волейболын хөгжлийн лиг, Шинэ эхлэл хүүхдийн лигийн тэмцээнүүд тус тус зохион байгууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Бүх нийтийн гүйлт арга хэмжээ 2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулагдлаа. Нийт 300 хүн оролцсон. Хутагтын нутаг-Шамбалын орноор 2024 100км-ын Явган алхалт зохион байгуулагдсан. Нийт Улаанбаатар хот, 3 аймгийн 122 алхагч оролцсон. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 24 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээний дагуу спортын 12 секц дугуйланд 38841 өсвөрийн болон насанд хүрэгчдийг хичээллүүлж, 43 төрийн байгууллага болон хувийн ААН-тэй заалаар үйлчлэх гэрээ байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх дасгал хөдөлгөөнийг хийлгэж давхардсан тоогоор 10099, шугаман бүжгийн спортоор хичээллэгсэд давхардсан тоогоор 5676, спортын үйл ажиллагаанд 43484, хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажил, арга хэмжээнд нийт 59259 иргэн хамрагдсан. | 100% |
| | 42 | | 1.5/. бүх шатны боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлийн хөтөлбөр агуулгыг боловсронгуй болгох, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх, суралцагчдыг спортын секц, дугуйланд хамран суралцуулах боломжоог бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлийн хөтөлбөр агуулгыг боловсронгуй болгох, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх, сагсан бөмбөг, волейбол зэрэг багийн спортыг аймаг орон нутагтаа хурдацтай хөгжүүлэх чиглэлээр санал санаачилга гарган ажиллаж төвийн болон сумдад хичээллэдэг секц дугуйлан болон заалыг бөмбөг, тор, тоног төхөөрөмж, спорт цогцолборт шагай харвааны өрөө байрлаж, ахмад харваачид, залуучууд, шагай сонирхогчид бэлтгэл сургуулилт хийх орчинг бүрдүүлж, үндэсний бөхийн барилдаанд бөхийн эд хэрэглэлээр ханган ажилласан. Биеийн тамир, спортын газар спортын 12 төрлөөр (сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөг, жюү жицу зэрэг) дугуйлан хичээллүүлж, аймгийн өсвөр үеийн 12 шигшээ багт 4259 гаруй тамирчид тогтмол хичээллэж байна. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 43 | | 1.6/. Биеийн тамирын багш, дасгалжуулагч, арга зүйч, мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, тэдгээрийг гадаад улсад бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Говь-Сүмбэр аймагт зохион байгуулагдсан шинэ спортын төрөл крикетийн спортын анхан шатны мэдлэг олгох сургалтанд тус газрын ахлах мэргэжилтэн, нийтийн биеийн тамирын арга зүйч, Төв аймагт зохион байгуулагдсан сорилын жишиг төв байгуулах сургалтанд төвийн болон сумдын 9 биеийн тамирын арга зүйч нар, Олон улсын С зэрэглэлийн сургалтанд сагсан бөмбөгийн дасгалжуулагч, Монголын Волейболын холбооны анхан шатны шүүгчийн сургалтанд нийтийн биеийн тамирын арга зүйч, Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулсан Бээжин хотын Спортын их сургуульд 10 хоног туршлага судлах хөтөлбөрт чөлөөт бөхийн дасгалжуулагч, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Биеийн тамир спорт тогтвортой хөгжил" Олон улсын эрдэм шинжилгээний хуралд ахлах мэргэжилтэн, чөлөөт бөхийн дасгалжуулагчид, "Спортын анагаах ухаан" эрдэм шинжилгээний хуралд нийтийн биеийн тамирын арга зүйч, усан спорт сургалтын төвийн дасгалжуулагч нар, тус газраас Монголын мэргэжлийн шүүгчдийн холбоо, Дорноговь аймгийн сагсан бөмбөгийн холбоотой хамтран 10 дугаар сарын 22,23-ны өдрүүдэд сагсан бөмбөгийн Олон улсын шүүгчийг урин сагсан бөмбөгийн шүүгч бэлтгэх сургалтыг зохион байгуулж 24 дасгалжуулагч, биеийн тамирын арга зүйчдийг хамруулж сертификат олгож мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэн ажиллаж байна. | 100% |
| | 44 | | 1.12/. Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, жил бүрийн улсын төсвийн төсөлд биеийн тамир спортын салбарын зардлыг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах. | Биеийн тамир, спортын газар 2024 онд 19 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан спортын 12 төрлөөр (сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөг, жюу жицу зэрэг) сургалт, дугуйлан хичээллүүлж, аймгийн өсвөр үеийн 12 шигшээ багт 630 гаруй тамирчид тогтмол хичээллэж байна. Тайлант онд аймгийн Биеийн тамир, спортын газар спортын 19 холбоо, клубтэй хамтран ажиллах гэрээ байгуулж сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөг, жюу жицу зэрэг спортын 12 төрлөөр сургалт, дугуйлан хичээллүүлж өсвөр үеийн 12 шигшээ багийг бүрдүүлэн 630 гаруй тамирчин тогтмол хамрагдаж байна. Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль 105, мөнгөн медаль 90, хүрэл медаль 87-г хүртсэнээр Олон улс, бүс, орон нутгийн чанартай 10 гаруй тэмцээнд аймгийн баг тамирчид оролцож амжилтын чанараа өмнө оныхоос 100%-иар ахиуллаа. Боксын шигшээ багийн тамирчин залуучуудын Азийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль хүртлээ. Олон улс, аймаг, бүсийн тэмцээнд оролцсон баг, тамирчдад аймгийн Засаг даргаас 4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тамирчдын бэлтгэлийг хангаан наадам, тэмцээнд оролцуулах, амжилтыг нэмэгдүүлэх зорилгоор “Хөгжлийн лиг-2024", "Шинэ эхлэл" хүүхдийн лиг, "Gobi guys" Сагсан бөмбөгийн лигийн тэмцээнийг зохион байгуулж 2028 гаруй тамирчид өрсөлдөж,9056 гаруй хүн үзсэн. ЕБС-ын сурагчдын дунд "Шинэ эхлэл" хүүхдийн лигийн тэмцээнийг зохион байгуулж, 65 багийн 600 гаруй өсвөрийн тамирчид оролцсон. 27,3 сая төгрөгийг зарцуулсан. Спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлэн, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг аймгийн төв, Замын-Үүд, Хатанбулаг, Улаанбадрах, Айраг, Хөвсгөл, Дэлгэрэх, Өргөн, Иххэт, Зүүнбаян | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | багт стандарт талбайн хэмжээтэй спорт цогцолборын барилга байнгын ажиллагаатай үйл ажиллагаа явуулж байна. Тус аймгийн Алтанширээ суманд Спортын ордон барих үйл ажиллагаа 50 хувийн гүйцэтгэлтэй, одоогоор ашиглалтанд ороогүй болно. | |
